



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

348. Сумын хөгжлийн индекс тооцох
аргачлал батлах тухай Дугаар 242 1321

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

349. Хувь хүний нууцын тухай хуулийн
4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт
Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг
зөрчсөн эсэх тухай маргааныг хянан
шийдвэрлэсэн тухай Дугаар 05 1361

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 7 дугаар Улаанбаатар
сарын 28-ны өдөр Дугаар 242 хот

Сумын хөгжлийн индекс тооцох аргачлал батлах тухай

Улсын Их Хурлын 2012 оны 60 дугаар тогтоол, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Сумын хөгжлийн индекс тооцох аргачлал”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Сумын хөгжлийн индекс тооцоход шаардагдах мэдээлэл, тэдгээрийг гаргах байгууллагын жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Сумдын хөгжлийн загвар”-ын дагуу аймгийн төвийн сумдаас бусад сумдын хөгжлийн индексийг хүн амын тооноос нь хамааруулан 3000 хүртэл, 3001-5000, 5001-с дээш, онцлог сум гэж 4 ангилж, ангилал тус бүрээр тооцон байр эзлүүлж, тухайн жилийн II улиралд багтаан зарлаж байхыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт даалгасугай.



3. Сумын хөгжлийн 2013 оны индексийг 2014 оны IY улиралд багтаан зарлаж, цаашид 2 жилд 1 удаа тооцож байхыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт үүрэг болгосугай.

4. Сумын хөгжлийн индекс тооцоход шаардлагатай мэдээллийг тогтоолын 2 дугаар хавсралтад тусгагдсан байгууллагуудаар гаргуулан сум бүрээр нэгтгэн боловсруулж тухайн жилийн I улиралд багтаан Эдийн засгийн хөгжлийн яаманд албан бичгээр хүргүүлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нар болон бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ЭДИЙН ЗАСГИЙН
ХӨГЖЛИЙН САЙД**

Н.БАТБАЯР

Засгийн газрын 2014 оны 242 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

СУМЫН ХӨГЖЛИЙН ИНДЕКС ТООЦОХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Сумын хөгжлийн индекс (цаашид “СХИ” гэх) нь Монгол Улсын сумдын хөгжлийн түвшинг илэрхийлэх нийлмэл үзүүлэлт юм. СХИ-ийг дараах тохиолдолд ашиглана:

1.1. СХИ-ийг сумын хөгжлийн ерөнхий түвшинг үнэлэхэд ашиглана.

1.2. СХИ-д тулгуурлан сул хөгжсөн орон нутагт чиглэсэн бодлого боловсруулна.

1.3. Монгол Улсын Засгийн газраас сумдыг хөгжүүлэхээр хэрэгжүүлж байгаа төслүүдийн үр дүнг хэмжихэд СХИ-ийг ашиглана.

Хоёр. Сумын хөгжлийн индекс тооцох
үзүүлэлтүүдийн тодорхойлолт, тооцох арга

2. Сумын хөгжлийн түвшинг дор дурдсан 7 бүлэг 33 үзүүлэлтийг ашиглан тооцно.



2.1. Хүн ам-тухайн суманд хүн амын төвлөрөл, ажиллах хүчний оролцоо ямар түвшинд байгааг тооцоолно. Энэ бүлэгт сумын хүн амын нягтшил, ажиллах хүчний оролцоо гэсэн 2 үзүүлэлт багтана.

2.1.1. хүн амын нягтшил

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын хүн амын 1 кв/км талбайд ногдох хүний тоогоор илэрхийлнэ.

Тооцох арга: Сумын нийт хүн амын тоог нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд харьцуулж тооцно.

2.1.2. ажиллах хүчний оролцоо

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын хөдөлмөрийн насны хүн амд эдийн засгийн идэвхтэй хүний эзлэх хувийг илэрхийлнэ.

Тооцох арга: Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

2.2. Нийгмийн үйлчилгээ-тухайн суманд нийгмийн үйлчилгээ хэр зэрэг үр өгөөжтэй байгааг илэрхийлнэ. Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг цэцэрлэгт хамрагдалтын индекс, ерөнхий боловсролын сургуулийн мэргэжилтэй багшийн хангалт, суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин, дотуур байрны хүрэлцээ хангамж, ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициент, 100 хүнд ногдох соёл урлагийн байгууллагын суудлын хүртээмж, 100 хүнд ногдох эмнэлгийн мэргэжилтний тоо, 100 хүнд ногдох эмнэлгийн үйлчилгээний хүртээмж гэсэн 8 үзүүлэлтээр илэрхийлнэ.

2.2.1. цэцэрлэгт хамрагдалтын индекс

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн жилд цэцэрлэгт хамрагдвал зохих нийт хүүхдэд (2-5 нас) цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн эзлэх хувиар илэрхийлнэ.

Тооцох арга: Цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн тоог цэцэрлэгт хамрагдвал зохих (2-5 нас) хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

2.2.2. ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт

Үзүүлэлтийн тодорхойлолт: Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа нийт багшид эзлэх дипломын буюу түүнээс дээш



боловсролын зэрэгтэй багшийн тоогоор илэрхийлэгдэнэ. Энэ нь тухайн сургуулийн багшийн хангалтын ерөнхий түвшинг харуулах бөгөөд мэргэжил тус бүрээр нарийвчлан гаргаж, ямар төрлийн хичээлийн багшийн хүрэлцээ хангамж хангалттай болон дутагдалтай байгааг харуулж болно.

Тооцох арга: Тухайн сумын ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа дипломын буюу түүнээс дээш боловсролын зэрэгтэй багшийн тоог сургуулийн нийт багшийн тоонд харьцуулж тооцно.

2.2.3. суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн жилд суурь боловсролд хамрагдвал зохих нийт хүүхдэд (6-14 нас) ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа тухайн насны хүүхдийн эзлэх хувийг илэрхийлнэ.

Тооцох арга: Сургуульд сурч байгаа 6-14 насны хүүхдийн тоог суурь боловсрол эзэмшвэл зохих нийт хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

2.2.4. дотуур байрны хүрэлцээ хангамж

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн жилд дотуур байранд суухаар хүсэлт гаргасан нийт хүүхдийн тоонд дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн эзлэх хувийг илэрхийлнэ.

Тооцох арга: Дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн тоог дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

2.2.5. ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициент

Үзүүлэлтийн тодорхойлолт: Сургуулийн хичээлийн байрны хүчин чадлын ашиглалтыг илэрхийлнэ.

Тооцох арга: Тухайн сургуульд суралцаж байгаа нийт хүүхдийн тоог хичээлийн байрны төлөвлөгдсөн хүчин чадалд харьцуулж тооцно. (1-ээс олон сургууль, хичээлийн байртай тохиолдолд тус бүрт ээлжийн коэффициентыг тооцон гаргаж, тэдгээрийн дундаж утгаар авна)

2.2.6. 100 хүнд ногдох соёл урлагийн байгууллагын суудлын хүртээмж

Үзүүлэлтийн тодорхойлолт: 100 хүн амд ногдох тухайн сумын соёл урлагийн байгууллагын суудлын тоогоор илэрхийлэгдэнэ.

Тооцох арга: Тухайн сумын соёл урлагийн байгууллагын суудлын тоог 100-аар илэрхийлсэн хүн амд харьцуулж тооцно.

2.2.7. 100 хүнд ногдох эмнэлгийн мэргэжилтний тоо

Үзүүлэлтийн тодорхойлолт: 100 хүн амд ногдох тухайн сумын эмнэлэгт ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний тоог илэрхийлнэ.

Тооцох арга: Тухайн сумын эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний тоог 100-аар илэрхийлсэн хүн амын тоонд харьцуулж тооцно.

2.2.8. 100 хүнд ногдох эмнэлгийн үйлчилгээний хүртээмж

Үзүүлэлтийн тодорхойлолт: 100 хүн амд ногдох эмнэлгийн орны тоог илэрхийлнэ. Энэ үзүүлэлт нь орон нутагт эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх материаллаг нөхцөл байдал ямар түвшинд байгаа болохыг харуулна.

Тооцох арга: Эмнэлгийн орны тоог 100-аар илэрхийлсэн хүн амын тоонд харьцуулж тооцно.

2.3. Засаглал-тухайн сумын удирдлагууд ямар түвшинд ажиллаж байгаа болон сум, орон нутгийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа нийгмийн асуудлуудад хэрхэн нөлөөлж байгааг харуулсан бүлэг юм. Энэ бүлэгт ажилгүйдлийн түвшин, шилжилт хөдөлгөөн, гэмт хэрэг илрүүлэлтийн хувийн жин, иргэдийн оролцоо, хөрөнгө оруулалтын зарцуулалтын хувийн жин гэсэн 5 үзүүлэлт багтана.

2.3.1. ажилгүйдлийн түвшин

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын эдийн засгийн идэвхтэй хүн амд эзлэх ажилгүй иргэдийн хувийг илэрхийлнэ.

Тооцох арга: Тухайн сумын ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж тооцно.

2.3.2. шилжилт хөдөлгөөн

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын хүн амын шилжилт хөдөлгөөнийг илэрхийлнэ.



Тооцох арга: Шилжин ирэлтээс шилжин явалтыг хасаж дундаж хүн амын тоонд харьцуулж тооцно. (дундаж хүн амын тоо = оны эхэнд байсан хүний тоо + оны эцэст байсан хүний тоо / 2)

2.3.3. гэмт хэрэг илрүүлэлтийн хувийн жин

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын бүртгэгдсэн гэмт хэрэгт илрүүлсэн гэмт хэргийн эзлэх хувийг илэрхийлнэ.

Тооцох арга: Илрүүлсэн гэмт хэргийн тоог нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоонд харьцуулж тооцно.

2.3.4. иргэдийн оролцоо

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэхэд оролцож буй иргэдийн оролцоог илэрхийлнэ.

Тооцох арга: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэх санал асуулгад оролцсон иргэдийн тоог сумын 18-аас дээш насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

2.3.5. хөрөнгө оруулалтын зарцуулалтын хувийн жин

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн суманд төсөвлөгдсөн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг илэрхийлнэ.

Тооцох арга: Тухайн жилд зарцуулсан улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төсөвлөсөн улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын дүнд харьцуулж тооцно.

2.4. Хөдөө аж ахуй-тухайн сумын хөдөө аж ахуйн хөгжлийн түвшинг хэмжинэ. Хөдөө аж ахуйг бэлчээр, хадлангийн 100 га талбайд ногдох малын тоо, тариалангийн зориулалттай нийт талбайн ашиглалтын хувийн жин, нийт хүн амд малчдын эзлэх хувийн жин, нэг хүнд ногдох малын тоо, нийт малчин өрхийн малчин хоршоонд хамрагдалтын хувийн жин гэсэн 5 үзүүлэлтээр илэрхийлнэ.

2.4.1. бэлчээр, хадлангийн 100 га талбайд ногдох малын тоо



Үзүүлэлтийн тодорхойлолт: Сумын нутаг дэвсгэр дэх бэлчээр хадлангийн нийт талбайн 100 га тутамд ногдож байгаа хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор илэрхийлнэ.

Тооцох арга: Тухайн сумын малын тоог бэлчээр, хадлангийн нийт талбайд харьцуулж тооцно. (Хонин толгойд шилжүүлэхдээ 1тэмээ-5хонь, 1адуу-7хонь, 1үхэр-6хонь, 1ямаа-0.9хонь гэсэн коэффициент ашиглана)

2.4.2. тариалангийн зориулалттай нийт талбайн ашиглалтын хувийн жин

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын газар тариалан эрхлэх боломжит талбайд үр тариа, төмс, хүнсний ногоо болон тэжээлийн ургамал тариалсан талбайн эзлэх хувийг илэрхийлнэ.

Тооцох арга: Үр тариа, төмс, хүнсний ногоо болон тэжээлийн ургамал тариалсан талбайн хэмжээг газар тариалан эрхлэх боломжит талбайд харьцуулж тооцно.

2.4.3. Нийт хүн амд малчдын эзлэх хувийн жин

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын нийт хүн амд малчдын эзлэх хувийг илэрхийлнэ.

Тооцох арга: Малчдын тоог сумын хүн амын тоонд харьцуулж тооцно.

2.4.4. 1 хүнд ногдох малын тоо

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын 1 хүнд ногдох малын тоог илэрхийлнэ.

Тооцох арга: Сумын хонин толгойд шилжүүлсэн малын тоог сумын хүн амын тоонд харьцуулж тооцно. (Хонин толгойд шилжүүлэхдээ 1тэмээ-5хонь, 1адуу-7хонь, 1үхэр-6хонь, 1ямаа-0.9хонь гэсэн коэффициент ашиглана)

2.4.5. Нийт малчин өрхийн малчин хоршоонд хамрагдалтын хувийн жин

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын малчин өрхөөс малчин хоршоонд хамрагдсан хувийг илэрхийлнэ.



Тооцох арга: Хоршоонд хамрагдсан малчин өрхийн тоог нийт малчин өрхийн тоонд харьцуулж тооцно.

2.5. Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ-тухайн суманд дэд бүтэц, инженерийн хангамж ямар хэмжээнд байгаа, түүнийг хэрхэн сайжруулж байгааг энэхүү үзүүлэлтээр тооцоолно. Энэ бүлэгт цахилгаан эрчим хүчээр хангагдсан албан байгууллага, өрхийн хувийн жин, дулаан хангамжийн системд холбогдсон барилга байгууламжийн хувийн жин, шаардлага хангасан ундны усны эх үүсвэрт хамрагдсан албан байгууллага, өрхийн хувийн жин, цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон албан байгууллага, өрхийн хувийн жин, инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн хувийн жин гэсэн 5 үзүүлэлт багтана.

2.5.1. цахилгаан эрчим хүчээр хангагдсан албан байгууллага, өрхийн эзлэх хувийн жин

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын нийт өрхөд эзлэх цахилгаан эрчим хүчээр хангагдсан албан байгууллага, өрхийн тоог илэрхийлнэ. Энэ үзүүлэлт нь орон нутгийн эрчим хүчээр хангагдсан байдлыг харуулна.

Тооцох арга: Цахилгаан эрчим хүчээр хангагдсан албан байгууллага, өрхийн тоог нийт өрхийн тоонд харьцуулж тооцно.

2.5.2. дулаан хангамжийн системд холбогдсон барилга байгууламжийн эзлэх хувийн жин

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын дулаан хангамжийн системд холбогдсон барилга, байгууламжийн хувийг илэрхийлнэ.

Тооцох арга: Дулаан хангамжийн системд холбогдсон барилга, (төсвийн байгууллага, зочид буудал, зоогийн газар, ахуй үйлчилгээний барилга) байгууламжийн талбайг нийт барилга (төсвийн байгууллага, зочид буудал, зоогийн газар, ахуй үйлчилгээний барилга) байгууламжийн талбайд харьцуулж тооцно.

2.5.3. шаардлага хангасан ундны усны эх үүсвэрт хамрагдсан албан байгууллага, өрхийн эзлэх хувийн жин

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнээс ус түгээх шугамаар дамжуулан усаар найдвартай тасралтгүй хангагддаг болон стандартын шаардлага



хангасан төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон худгаас ундны усаа авдаг албан байгууллага, өрхийн хувийг илэрхийлнэ.

Тооцох арга: Төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнээс ус түгээх шугамаар дамжуулан усаар найдвартай тасралтгүй хангагддаг болон стандартын шаардлага хангасан төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон худгаас ундны усаа авдаг албан байгууллага, өрхийн тоог сумын нийт албан байгууллага, өрхийн тоонд харьцуулж тооцно. (Албан байгууллага болон өрхийг тус тусад нь тооцож нийлбэр дүнгээр үндсэн үзүүлэлтийг гаргана)

2.5.4. цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон албан байгууллага, өрхийн эзлэх хувийн жин

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон албан байгууллага, өрхийн хувийг илэрхийлнэ.

Тооцох арга: Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон албан байгууллага, өрхийн тоог нийт албан байгууллага, өрхийн тоонд харьцуулж тооцно. (Албан байгууллага болон өрхийг тус тусад нь тооцож нийлбэр дүнгээр үндсэн үзүүлэлтийг гаргана)

2.5.5. төвлөрсөн болон бие даасан инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувийн жин

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын нийт орон сууцанд эзлэх төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон болон бие даасан инженерийн хангамжтай орон сууцны хувийг илэрхийлнэ. Төвлөрсөн шугам сүлжээ гэж хот, суурин газрын хүн амыг цэвэр ус, дулаан, цахилгаанаар хангах, бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээний байгууламжийг хэлнэ. Бие даасан инженерийн хангамжтай орон сууц гэдэг нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй боловч цэвэр ус, дулаан, цахилгаанаар хангагдсан, бохир усыг зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээний байгууламжтай орон сууцыг хэлнэ. Шугам сүлжээ гэсэн ойлголтод цэвэр ус дамжуулах, хуваарилах, хэрэглэгчдэд хүргэх, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах байгууламжийг хамааруулна. Орон сууц гэдэгт монгол гэр, амины байшин сууц, нийтийн орон сууцыг хамруулж ойлгоно.

Тооцох арга: Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн тоог нийт өрхийн тоонд харьцуулж тооцно.



2.6. Байгаль хамгаалал-тухайн сум нь байгаль орчноо ямар түвшинд хамгаалдаг, нөхөн сэргээдэг, энэ нь үр дүнтэй болдог эсэхийг тодорхойлно. Энэ бүлэгт 1 хүнд ногдох орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ, хамгаалж тохижуулсан булаг шанд, усны эх үүсвэр, 1 хүнд ногдох байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлын хэмжээ гэсэн 3 үзүүлэлт байна.

2.6.1. 1 хүнд ногдох орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн 1 хүнд ногдох хэмжээг илэрхийлнэ.

Тооцох арга: Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээг сумын хүн амын тоонд харьцуулж тооцно.

2.6.2. хамгаалж тохижуулсан булаг шанд, усны эх үүсвэр

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын нийт булаг шанд, усны эх үүсвэрээс хамгаалж тохижуулсан булаг шанд, усны эх үүсвэрийн эзлэх хувийг илэрхийлнэ.

Тооцох арга: Хамгаалж тохижуулсан булаг шанд, усны эх үүсвэрийн тоог нийт булаг шанд, усны эх үүсвэрт харьцуулж тооцно.

2.6.3. 1 хүнд ногдох байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хэмжээ

Үзүүлэлтийн тодорхойлолт: 1 хүнд ногдох байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хэмжээг илэрхийлнэ.

Тооцох арга: Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хэмжээг сумын нийт хүн амд харьцуулж тооцно.

2.7. Эдийн засаг-тухайн сумын төсөв, санхүүгийн байдал ямар түвшинд байгаа болон иргэдийн бизнес эрхлэлтийн байдлыг тодорхойлно. Энэ бүлэгт 1 хүнд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээ, 1 хүнд ногдох хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ, 1 хүнд ногдох үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээ, 1 хүнд ногдох татварын орлогын хэмжээ, бизнес эрхлэлтийн түвшин гэсэн 5 үзүүлэлт багтана.

2.7.1. 1 хүнд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээ



Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын хөрөнгө оруулалтын 1 хүнд ногдох хэмжээг илэрхийлнэ.

Тооцох арга: Сумын нийт хөрөнгө оруулалтын хэмжээг нийт хүн амын тоонд харьцуулж тооцно. (Улсын төсөв, орон нутгийн төсвөөс тухайн суманд хуваарилагдсан төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө хамаарна)

2.7.2. 1 хүнд ногдох хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын хадгаламжийн үлдэгдлийн 1 хүнд ногдох хэмжээг илэрхийлнэ.

Тооцох арга: Оны эцсийн хадгаламжийн үлдэгдлийн хэмжээг нийт хүн амд харьцуулж тооцно.

2.7.3. 1 хүнд ногдох үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээ

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдлийн 1 хүнд ногдох хэмжээг илэрхийлнэ.

Тооцох арга: Оны эцсийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээг нийт хүн амд харьцуулж тооцно.

2.7.4. 1 хүнд ногдох татварын орлогын хэмжээ

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумаас улс, орон нутаг (аймаг, сумын)-ийн төсөвт төвлөрүүлж буй татварын орлогын нэг хүнд ногдох хэмжээг илэрхийлнэ.

Тооцох арга: Тухайн сумаас улс, орон нутаг (аймаг, сумын)-ийн төсөвт төвлөрүүлж буй татварын орлогыг нийт хүн амын тоонд харьцуулж тооцно.

2.7.5. бизнес эрхлэлтийн түвшин

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын нийт өрхөд жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа өрхийн эзлэх хувийг илэрхийлнэ.



Тооцох арга: Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа өрхийн тоог нийт өрхийн тоонд харьцуулж тооцно.

Гурав. Сумын хөгжлийн индекс тооцох дараалал, баримтлах зарчим, мэдээллийн эх үүсвэр

3. Сумын хөгжлийн индексийг тооцох дараалал нь:

3.1. Холбогдох мэдээллийн эх үүсвэрээс шаардлагатай мэдээллийг цуглуулан, шалгаж мэдээллийн сан бүрдүүлэх;

3.2. Мэдээллийн санд бүрдүүлсэн мэдээлэлд үндэслэн сумын хөгжлийн индексийн холбогдох үзүүлэлтүүдийг тооцох, Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоолын дагуу сумдыг хүн амын тооноос нь хамааруулан 4 ангилах;

3.3. Ангилал тус бүрт тухайн нэг үзүүлэлтийн хувийн индексийг тооцох;

3.4. Үзүүлэлтийн хувийн индексийн жигнэсэн дунджаар сумын хөгжлийн индексийг тооцох.

4. СХИ-ийг дараах зарчмыг баримтлан тооцно. Үүнд:

4.1. СХИ тооцох арга нь олон улсын нийтлэг арга зүйтэй нийцсэн байх;

4.2. Үзүүлэлтүүд нь хөгжлийн түвшинг илэрхийлэхүйц байх;

4.3. Мэдээллийн эх үүсвэр тодорхой, мэдээлэл нь тогтмол, үнэн бодитой байх;

4.4. Үндэсний түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн байх;

4.5. Хэмжих боломжтой тодорхой үзүүлэлтийг сонгосон байх.

5. СХИ-ийг тооцоход шаардлагатай мэдээллийг дараах байгууллагаас авна.

5.1. Салбарын яам, Засгийн газрын агентлаг;

5.2. Үндэсний статистикийн хороо;



5.3. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар.

Дөрөв. Сумын хөгжлийн индексийг тооцох арга зүй

4.1. Хүн ам-тухайн суманд хүн амын төвлөрөл, ажиллах хүчний оролцоо ямар түвшинд байгааг тооцоолно. Энэ бүлэгт сумын хүн амын нягтшил, ажиллах хүчний оролцоо гэсэн 2 үзүүлэлт багтана.

	Үзүүлэлт	Тооцох арга
4.1.1	Хүн амын нягтшил	Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын хүн амын 1 кв/км талбайд ногдох хүний тоогоор илэрхийлнэ.
		<p>Сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээг нийт хүн амын тоонд харьцуулж тооцно.</p> $\text{ХАН}_{\text{ха}} = \frac{\text{СХАТ}}{\text{СНДХ}}$ <p>$\text{ХАН}_{\text{ха}}$ – Хүн амын нягтшил СХАТ – Сумын хүн амын тоо СНДХ – Сумын нутаг дэвсгэрийн хэмжээ (кв/м)</p>
4.1.2	Ажиллах хүчний оролцоо	Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын хөдөлмөрийн насны хүн амд эдийн засгийн идэвхтэй хүний эзлэх хувийг илэрхийлнэ.
		<p>Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.</p> $\text{АХО}_{\text{ха}} = \frac{\text{ЭЗИХАТ}}{\text{ХНХТ}}$ <p>$\text{АХО}_{\text{ха}}$ – Ажиллах хүчний оролцоо ЭЗИХАТ- Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо ХНХТ- Хөдөлмөрийн насны хүний тоо</p>

4.2. Нийгмийн үйлчилгээ-тухайн суманд нийгмийн үйлчилгээ хэр зэрэг үр өгөөжтэй байгааг тооцоолно. Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг цэцэрлэгт хамрагдалтын индекс, ерөнхий боловсролын сургуулийн мэргэжилтэй багшийн хангалт, бага, суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин, дотуур байрны хүрэлцээ хангамж, ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициент, 100 хүнд ногдох соёл урлагийн байгууллагын суудлын хүртээмж, 100 хүнд ногдох эмнэлгийн мэргэжилтний тоо, 100 хүнд ногдох эмнэлгийн үйлчилгээний хүртээмж гэсэн 8 үзүүлэлтээр илэрхийлнэ.



	Үзүүлэлт	Тооцох арга
4.2.1	Цэцэрлэгт хамрагдалтын индекс	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн жилд цэцэрлэгт хамрагдвал зохих нийт хүүхдэд (2-5 нас) цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн эзлэх хувиар илэрхийлнэ.</p> <p>Цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн тоог цэцэрлэгт хамрагдвал зохих (2-5 нас) хүүхдийн тоонд харьцуулж тооцно.</p> $\text{ЦХИ}_{\text{НҮ}} = \frac{\text{ЦХБХТ}}{\text{ЦХЗХТ}}$ <p>$\text{ЦХИ}_{\text{НҮ}}$-Цэцэрлэгт хамрагдалтын индекс ЦХБХТ-Цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн тоо ЦХЗХТ-Цэцэрлэгт хамрагдвал зохих хүүхдийн тоо</p>
4.2.2	Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа нийт багшид эзлэх дипломын буюу түүнээс дээш боловсролын зэрэгтэй багшийн тоогоор илэрхийлэгдэнэ. Энэ нь тухайн сургуулийн багшийн хангалтын ерөнхий түвшинг харуулах бөгөөд мэргэжил тус бүрээр нарийвчлан гаргаж, ямар төрлийн хичээлийн багшийн хүрэлцээ хангамж хангалттай болон дутагдалтай байгааг харуулж болно.</p> <p>Тухайн сумын ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа дипломын буюу түүнээс дээш боловсролын зэрэгтэй багшийн тоог сургуулийн нийт багшийн тоонд харьцуулж тооцно.</p> $\text{ЕБСМБХЖ}_{\text{НҮ}} = \frac{\text{ЕБСДБЗБТ}}{\text{САБНБТ}}$ <p>$\text{ЕБСМБХ}_{\text{НҮ}}$-Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт</p> <p>ЕБСДБЗБТ-Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа дипломын буюу түүнээс дээш боловсролын зэрэгтэй багшийн тоо САБНБТ-Сургуульд ажиллаж байгаа нийт багшийн тоо</p>



4.2.3	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн жилд суурь боловсролд хамрагдвал зохих нийт хүүхдэд (6-14 нас) ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа тухайн насны хүүхдийн эзлэх хувийг илэрхийлнэ.</p> <p>Сургуульд сурч байгаа 6-14 насны хүүхдийн тоог суурь боловсрол эзэмшвэл зохих нийт хүүхдийн тоонд харьцуулж тооцно.</p> $БСБХСЦЖ_{нҮ} = \frac{ССБХТ}{СБЭЗХТ}$ <p>БСБХСЦЖ_{нҮ}-Бага, суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин</p> <p>ССБХТ-Сургуульд сурч байгаа6-14 насны хүүхдийн тоо СБЭЗХТ-Бага, суурь боловсрол эзэмшвэл зохих нийт хүүхдийн тоо</p>
4.2.4	Дотуур байрны хүрэлцээ хангамж	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн жилд дотуур байранд суухаар хүсэлт гаргасан нийт хүүхдийн тоонд дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн эзлэх хувийг илэрхийлнэ.</p> <p>Дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн тоог дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан хүүхдийн тоонд харьцуулж тооцно.</p> $ДБХХ_{нҮ} = \frac{ДБАБХТ}{ДБАХТ}$ <p>ДБХХ_{нҮ}-Дотуур байрны хүрэлцээ хангамж</p> <p>ДБАБХТ-Дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн тоо ДБАХТ-Дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан хүүхдийн тоо</p>



<p>4.2.5</p>	<p>Ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициент</p>	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Сургуулийн хичээлийн байрны хүчин чадлын ашиглалтыг илэрхийлнэ.</p> <p>Тухайн сургуульд суралцаж байгаа нийт хүүхдийн тоог хичээлийн байрны төлөвлөгдсөн хүчин чадалд харьцуулж тооцно. (1-ээс олон сургууль, хичээлийн байртай тохиолдолд тус бүрт ээлжийн коэффициентыг тооцон гаргаж, тэдгээрийн дундаж утгаар авна)</p> $ЕБСЭК_{нү} = \frac{ТССБХТ}{ХБАТХЧ}$ <p>ЕБСЭК_{нү}-Ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициент</p> <p>ТССБХТ-Тухайн сургуульд суралцаж байгаа хүүхдийн тоо ХБАТХЧ-Хичээлийн байрны төлөвлөгдсөн хүчин чадал (хүүхдийн суудлын тоогоор илэрхийлэгддэг үзүүлэлт)</p>
<p>4.2.6</p>	<p>100 хүнд ногдох соёл урлагийн байгууллагын суудлын хүртээмж</p>	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: 100 хүн амд ногдох тухайн сумын соёл урлагийн байгууллагын суудлын тоогоор илэрхийлэгдэнэ.</p> <p>Тухайн сумын соёл урлагийн байгууллагын суудлын тоог 100-аар илэрхийлсэн хүн амд харьцуулж тооцно.</p> $СУБСТ_{нү} = \frac{ССУБСТ}{СХАТ} * 100$ <p>СУБСТ_{нү} – 100 хүнд ногдох соёл урлагийн байгууллагын суудлын хүртээмж</p> <p>ССУБСТ – Сумын соёл урлагийн байгууллагын суудлын тоо СХАТ – Сумын хүн амын тоо</p>



<p>4.2.7</p>	<p>100 хүнд ногдох эмнэлгийн мэргэжилтний тоо</p>	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: 100 хүн амд ногдох тухайн сумын эмнэлэгт ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний тоог илэрхийлнэ.</p> <p>Тухайн сумын эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний тоог 100-аар илэрхийлсэн хүн амын тоонд харьцуулж тооцно.</p> $ЭМТ_{HY} = \frac{ЭМТ}{СХАТ} * 100$ <p>ЭМТ_{HY} – 100 хүнд ногдох эмнэлгийн мэргэжилтний тоо</p> <p>ЭМТ – Эмнэлгийн мэргэжилтний тоо СХАТ – Сумын хүн амын тоо</p>
<p>4.2.8</p>	<p>100 хүнд ногдох эмнэлгийн үйлчилгээний хүртээмж</p>	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: 100 хүн амд ногдох эмнэлгийн орны тоог илэрхийлнэ. Энэ үзүүлэлт нь орон нутагт эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх материаллаг нөхцөл байдал ямар түвшинд байгаа харуулна.</p> <p>Эмнэлгийн орны тоог 100-аар илэрхийлсэн хүн амын тоонд харьцуулж тооцно</p> $ЭҮХ_{HY} = \frac{ЭОТ}{СХАТ} * 100$ <p>ЭҮХ_{HY} - 100 хүнд ногдох эмнэлгийн үйлчилгээний хүртээмж</p> <p>ЭОТ - Эмнэлгийн орны тоо СХАТ - Сумын хүн амын тоо</p>

4.3. Засаглал-тухайн сумын удирдлагууд ямар түвшинд ажиллаж байгаа болон сум, орон нутгийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа нийгмийн асуудлуудад хэрхэн нөлөөлж байгааг харуулсан бүлэг юм. Энэ бүлэгт ажилгүйдлийн түвшин, шилжилт хөдөлгөөн, гэмт хэрэг илрүүлэлтийн хувийн жин, иргэдийн оролцоо, хөрөнгө оруулалтын зарцуулалтын хувийн жин гэсэн 5 үзүүлэлт багтана.



	Үзүүлэлт	Томъёолол
4.3.1	Ажилгүйдлийн түвшин	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын эдийн засгийн идэвхтэй хүн амд эзлэх ажилгүй иргэдийн хувийг илэрхийлнэ.</p> <p>Тухайн сумын ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж тооцно.</p> $AT_3 = \frac{AIT}{ЭЗИХАТ}$ <p>AT₃-Ажилгүйдлийн түвшин АИТ-Ажилгүй иргэдийн тоо ЭЗИХАТ-Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо</p>
4.3.2	Шилжилт хөдөлгөөн	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын хүн амын шилжилт хөдөлгөөнийг илэрхийлнэ.</p> <p>Шилжин ирэлтээс шилжин явалтыг хасаж дундаж хүн амын тоонд харьцуулж (дундаж хүн амын тоо =оны эхэнд байсан хүний тоо + оны эцэст байсан хүний тоо / 2) тооцно</p> $ШХ_3 = \frac{ШИ - ШЯ}{ДХАТ}$ <p>ШХ₃- Шилжилт хөдөлгөөн ШИ - Шилжин ирэгсэд ШЯ - Шилжин явагсад ДХАТ- Дундаж хүн амын тоо</p>
4.3.3	Гэмт хэрэг илрүүлэлтийн хувийн жин	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын бүртгэгдсэн гэмт хэрэгт илрүүлсэн гэмт хэргийн эзлэх хувийг илэрхийлнэ.</p> <p>Илрүүлсэн гэмт хэргийн тоог нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоонд харьцуулж тооцно.</p> $ГХИХЖ_3 = \frac{ИГХТ}{БГХТ}$ <p>ГХИХЖ₃-Гэмт хэрэг илрүүлэлтийн хувийн жин</p> <p>ИГХТ-Илрүүлсэн гэмт хэргийн тоо БГХТ-Бүртгэсэн гэмт хэргийн тоо</p>



4.3.4	Иргэдийн оролцоо	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэхэд оролцож буй иргэдийн оролцоог илэрхийлнэ.</p> <p>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэх санал асуулгад оролцсон иргэдийн тоог сумын 18-аас дээш насны хүн амын тоонд харьцуулж тооцно.</p> $ИО_3 = \frac{САОИ}{АДНХАТ}$ <p>ИО₃-Иргэдийн оролцоо САОИ-Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэх санал асуулгад оролцсон иргэдийн тоо АДНХАТ-18-аас дээш насны хүн амын тоо</p>
4.3.5	Хөрөнгө оруулалтын зарцуулалтын хувийн жин	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт:Тухайн суманд төсөвлөгдсөн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг илэрхийлнэ.</p> <p>Тухайн жилд зарцуулсан улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төсөвлөсөн улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын дүнд харьцуулж тооцно.</p> $ХОЗХЖ_3 = \frac{ЗУОНТХО}{ТУОНТХО}$ <p>ХОЗХЖ₃-Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалтын хувийн жин</p> <p>ЗУОНТХО-Тухайнжилд зарцуулсан улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө (сая.төгрөг) ТУОНТХО-Тухайн жилд төсөвлөсөн улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө (сая.төгрөг)</p>

4.4. Хөдөө аж ахуй-тухайн сумын хөдөө аж ахуйн хөгжлийн түвшинг хэмжинэ. Хөдөө аж ахуйг бэлчээр, хадлангийн 100 га талбайд ногдох малын тоо, тариалангийн зориулалттай нийт талбайн ашиглалтын



хувийн жин, нийт хүн амд малчдын эзлэх хувийн жин, 1 хүнд ногдох малын тоо, нийт малчин өрхийн малчин хоршоонд хамрагдалтын хувийн жин гэсэн 5 үзүүлэлтээр илэрхийлнэ.

	Үзүүлэлт	Томъёолол
4.4.1	Бэлчээр, хадлангийн 100 га талбайд ногдох малын тоо	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Сумын нутаг дэвсгэр дэх бэлчээр хадлангийн нийт талбайн 100 га тутамд ногдож байгаа хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор илэрхийлнэ.</p> <p>Тухайн сумын малын тоог бэлчээр, хадлангийн нийт талбайд харьцуулж тооцно. (Хонин толгойд шилжүүлэхдээ 1тэмээ-5хонь, 1адуу-7хонь, 1үхэр-6хонь, 1ямаа-0.9хонь гэсэн коэффициент ашиглана)</p> $БХМТ_{хээ} = \frac{СМТ}{СБХНТ} * 100$ <p>БХМТ_{хээ} - Бэлчээр, хадлангийн 100 га талбайд ногдох малын тоо</p> <p>СМТ – Сумын нийт малын тоо (хонин толгойгоор)</p> <p>СБХНТ - Сумын бэлчээр, хадлангийн нийт талбайн хэмжээ (га)</p>
4.4.2	Тариалангийн зориулалттай нийт талбайн ашиглалтын хувийн жин	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын газар тариалан эрхлэх боломжит талбайд үр тариа, төмс, хүнсний ногоо болон тэжээлийн ургамал тариалсан талбайн эзлэх хувийг илэрхийлнэ.</p> <p>Үр тариа, төмс, хүнсний ногоо болон тэжээлийн ургамал тариалсан талбайн хэмжээг газар тариалан эрхлэх боломжит талбайд харьцуулж тооцно.</p> $ТХЖ_{хээ} = \frac{НТХТ}{СГТЭБТ}$ <p>ТХЖ_{хээ} -Тариалангийн зориулалттай нийт талбайн ашиглалтын хувийн жин</p> <p>НТХТ-Нийт тариалалт хийсэн талбайн хэмжээ (га)</p> <p>СГТЭБТ-Сумын газар тариалан эрхлэх боломжит талбайн хэмжээ (га)</p>



4.4.3	Нийт хүн амд малчдын эзлэх хувийн жин	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын нийт хүн амд малчдын эзлэх хувийг илэрхийлнэ.</p> <p>Малчдын тоог сумын хүн амын тоонд харьцуулж тооцно.</p> $МЭХЖ_{хаа} = \frac{MT}{СХАТ}$ <p>$МЭХЖ_{хаа}$ - Нийт хүн амд малчдын эзлэх хувийн жин</p> <p>MT-Малчдын тоо СХАТ-Сумын хүн амын тоо</p>
4.4.4	1 хүнд ногдох малын тоо	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын 1 хүнд ногдох малын тоог илэрхийлнэ.</p> <p>Сумын хонин толгойд шилжүүлсэн малын тоог сумын хүн амын тоонд харьцуулж тооцно. (Хонин толгойд шилжүүлэхдээ 1тэмээ-5хонь, 1адуу-7хонь, 1үхэр-6хонь, 1ямаа-0.9хонь гэсэн коэффициент ашиглана)</p> $НХНМТ_{хаа} = \frac{СМТ}{СХАТ}$ <p>$НХНМТ_{хаа}$ - 1 хүнд ногдох малын тоо</p> <p>$СМТ$ - Сумын малын тоо (хонин толгойгоор) $СХАТ$ - Сумын хүн амын тоо</p>
4.4.5	Нийт малчин өрхийн малчин хоршоонд хамрагдалтын хувийн жин	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын малчин өрхөөс малчин хоршоонд хамрагдсан хувийг илэрхийлнэ.</p> <p>Хоршоонд хамрагдсан малчин өрхийн тоог нийт малчин өрхийн тоонд харьцуулж тооцно.</p> $МӨМХЭТ_6 = \frac{ХЭМӨТ}{НМӨТ}$ <p>$МӨМХЭТ_6$ - Нийт малчин өрхийн малчин хоршоонд хамрагдалтын хувийн жин</p> <p>$ХЭМӨТ$ - Хоршоонд элссэн малчин өрхийн тоо $НМӨТ$ - Тухайн сумын нийт малчин өрхийн тоо</p>



4.5. Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ-тухайн суманд дэд бүтэц, инженерийн хангамж ямар хэмжээнд байгаа, түүнийг хэрхэн сайжруулж байгааг энэхүү үзүүлэлтээр тооцоолно. Энэ бүлэгт цахилгаан эрчим хүчээр хангагдсан албан байгууллага, өрхийн хувийн жин, дулаан хангамжийн системд холбогдсон барилга байгууламжийн хувийн жин, шаардлага хангасан ундны усны эх үүсвэрт хамрагдсан албан байгууллага, өрхийн хувийн жин, цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон албан байгууллага, өрхийн хувийн жин, инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн хувийн жин гэсэн 5 үзүүлэлт багтана.

	Үзүүлэлт	Томъёолол
4.5.1	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан албан байгууллага, өрхийн эзлэх хувийн жин	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын нийт өрхөд эзлэх цахилгаан эрчим хүчээр хангагдсан албан байгууллага, өрхийн тоог илэрхийлнэ. Энэ үзүүлэлт нь орон нутгийн эрчим хүчээр хангагдсан байдлыг харуулна.</p> <p>Цахилгаан эрчим хүчээр хангагдсан албан байгууллага, өрхийн тоог нийт өрхийн тоонд харьцуулж тооцно. (Албан байгууллага болон өрхийг тус тусад нь тооцож нийлбэр дүнгээр үндсэн үзүүлэлтийг гаргана)</p> $\text{ЦЭХХБӨХЖ}_{\text{дб}} = \text{ЦЭХХБХЖ}_{\text{дб}} + \text{ЦЭХХӨХЖ}_{\text{дб}}$ <p>$\text{ЦЭХХБӨХЖ}_{\text{дб}}$ – Цахилгаан эрчим хүчээр хангагдсан байгууллага, өрхийн эзлэх хувийн жин</p> <p>ЦЭХХБӨТ - Цахилгаан эрчим хүчээр хангагдсан баигууллагын тоо</p> <p>$\text{ЦЭХХӨХЖ}_{\text{дб}}$ – Цахилгаан эрчим хүчээр хангагдсан өрхийн эзлэх хувийн жин</p> $\text{ЦЭХХБХЖ}_{\text{дб}} = \frac{\text{ЦЭХХБӨТ}}{\text{НӨТ}}$ <p>$\text{ЦЭХХБХЖ}_{\text{дб}}$ – Цахилгаан эрчим хүчээр хангагдсан байгууллагын эзлэх хувийн жин</p> <p>ЦЭХХБӨТ - Цахилгаан эрчим хүчээр хангагдсан байгууллагын тоо</p> <p>НӨТ – Нийт байгууллагын тоо</p> $\text{ЦЭХХӨХЖ}_{\text{дб}} = \frac{\text{ЦЭХХӨТ}}{\text{НӨТ}}$ <p>$\text{ЦЭХХӨХЖ}_{\text{дб}}$ – Цахилгаан эрчим хүчээр хангагдсан өрхийн эзлэх хувийн жин</p> <p>ЦЭХХӨТ - Цахилгаан эрчим хүчээр хангагдсан өрхийн тоо</p> <p>НӨТ – Нийт өрхийн тоо</p>



<p>4.5.2</p>	<p>Дулаан хангамжийн системд холбогдсон барилга байгууламжийн эзлэх хувийн жин</p>	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын дулаан хангамжийн системд холбогдсон барилга, байгууламжийн хувийг илэрхийлнэ.</p>
		<p>Дулаан хангамжийн системд холбогдсон барилга, (төсвийн байгууллага, зочид буудал, зоогийн газар, ахуй үйлчилгээний барилга) байгууламжийн талбайг нийт барилга (төсвийн байгууллага, зочид буудал, зоогийн газар, ахуй үйлчилгээний барилга) байгууламжийн талбайд харьцуулж тооцно.</p> $\text{ДХСХББХЖ}_{\text{дб}} = \frac{\text{ДХСХББТ}}{\text{НББТ}}$ <p>$\text{ДХСХББХЖ}_{\text{дб}}$ -Дулаан хангамжийн системд холбогдсон барилга байгууламжийн эзлэх хувийн жин</p> <p>ДХСХББТ-Дулаан хангамжийн системд холбогдсон барилга байгууламжийн талбай (кв.м)(төсвийн байгууллага, зочид буудал, зоогийн газар, ахуй үйлчилгээний барилга) НББТ-Нийт барилга байгууламжийн талбай (кв.м) (төсвийн байгууллага, зочид буудал, зоогийн газар, ахуй үйлчилгээний барилга)</p>



<p>4.5.3</p>	<p>Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрт хамрагдсан албан байгууллага, өрхийн эзлэх хувийн жин</p>	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнээс ус түгээх шугамаар дамжуулан усаар найдвартай тасралтгүй хангагддаг болон стандартын шаардлага хангасан төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон худгаас ундны усаа авдаг албан байгууллага, өрхийн хувийг илэрхийлнэ.</p> <p>Төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнээс ус түгээх шугамаар дамжуулан усаар найдвартай тасралтгүй хангагддаг болон стандартын шаардлага хангасан төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон худгаас ундны усаа авдаг албан байгууллага, өрхийн тоог сумын нийт албан байгууллага, өрхийн тоонд харьцуулж тооцно. (Албан байгууллага болон өрхийг тус тусад нь тооцож нийлбэр дүнгээр үндсэн үзүүлэлтийг гаргана)</p> <p>ШХУУЭХ_{дб} = ШХУУЭҮХА + ШХУУЭХӨ</p> <p>ШХУУЭХ_{дб} -Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрт хамрагдсан албан байгууллага, өрхийн эзлэх хувийн жин</p> <p>ШХУУЭҮХА-Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрт хамрагдсан албан байгууллагын хувийн жин</p> <p>ШХУУЭХӨ —Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрт хамрагдсан өрхийн хувийн жин</p> <p>ШХУУЭҮХА = $\frac{\text{ТУХШСХА}}{\text{НА}}$</p> <p>ШХУУЭҮХА-Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрт хамрагдсан албан байгууллагын хувийн жин ТУХШСХА -Төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнээс ус түгээх шугамаар дамжуулан усаар найдвартай тасралтгүй хангагддаг болон стандартын шаардлага хангасан төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон албан байгууллагын тоо НА -Нийт албан байгууллагын тоо</p> <p>ШХУУЭХӨ = $\frac{\text{ТУХШСХӨ}}{\text{НӨ}}$</p> <p>ШХУУЭХӨ - Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрт хамрагдсан өрхийн хувийн жин</p> <p>ТУХШСХӨ -Төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнээс ус түгээх шугамаар дамжуулан усаар найдвартай тасралтгүй хангагддаг болон стандартын шаардлага хангасан төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон өрхийн тоо НӨ - Нийт өрхийн тоо</p>
--------------	---	---



<p>4.5.4</p>	<p>Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон албан байгууллага, өрхийн эзлэх хувийн жин</p>	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон албан байгууллага, өрхийн хувийг илэрхийлнэ.</p> <p>Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон албан байгууллага, өрхийн тоог нийт албан байгууллага, өрхийн тоонд харьцуулж тооцно. (Албан байгууллага болон өрхийг тус тусад нь тооцож нийлбэр дүнгээр үндсэн үзүүлэлтийг гаргана)</p> <p>ЦБАТШСХ_{дб} = ЦБАТАХЖ + ЦБАТӨХЖ</p> <p>ЦБАТШСХ_{дб} - Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон албан байгууллага, өрхийн эзлэх хувийн жин</p> <p>ЦБАТАХЖ - Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон албан байгууллагын хувийн жин</p> <p>ЦБАТӨХЖ — Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон өрхийн хувийн жин</p> $\text{ЦБАТАХЖ} = \frac{\text{ЦБАТАТ}}{\text{НА}}$ <p>ЦБАТАХЖ - Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон албан байгууллагын хувийн жин</p> <p>ЦБАТАТ - Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон албан байгууллагын тоо</p> <p>НА - Нийт албан байгууллагын тоо</p> $\text{ЦБАТӨХЖ} = \frac{\text{ЦБАТӨТ}}{\text{НӨ}}$ <p>ЦБАТӨХЖ - Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон өрхийн хувийн жин</p> <p>ЦБАТӨТ - Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон өрхийн тоо</p> <p>НӨ - Нийт өрхийн тоо</p>



<p>4.5.5</p>	<p>Төвлөрсөн болон бие даасан инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувийн жин</p>	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын нийт орон сууцанд эзлэх төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон болон бие даасан инженерийн хангамжтай орон сууцны хувийг илэрхийлнэ. Төвлөрсөн шугам сүлжээ гэж хот, суурин газрын хүн амыг цэвэр ус, дулаан, цахилгаанаар хангах, бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээний байгууламжийг хэлнэ. Бие даасан инженерийн хангамжтай орон сууц гэдэг нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй боловч цэвэр ус, дулаан, цахилгаанаар хангагдсан, бохир усыг зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээний байгууламжтай орон сууцыг хэлнэ. Шугам сүлжээ гэсэн ойлголтод цэвэр ус дамжуулах, хуваарилах, хэрэглэгчдэд хүргэх, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах байгууламжийг хамааруулна. Орон сууц гэдэгт монгол гэр, амины байшин сууц, нийтийн орон сууцыг хамруулж ойлгоно.</p> <p>Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн тоог нийт өрхийн тоонд харьцуулж тооцно.</p> $\text{ИБХОСАӨХЖ}_{\text{дб}} = \frac{\text{ИБХОСАӨТ}}{\text{НӨТ}}$ <p>ИБХОСАӨХЖ_{дб} - Төвлөрсөн болон бие даасан инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувийн жин ИБХОСАӨТ -Төвлөрсөн болон бие даасан инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн тоо НӨТ – Нийт өрхийн тоо</p>
--------------	--	---

4.6. Байгаль хамгаалал-тухайн сум нь байгаль орчноо ямар түвшинд хамгаалдаг, нөхөн сэргээдэг, энэ нь үр дүнтэй болдог эсэхийг тодорхойлно. Энэ бүлэгт 1 хүнд ногдох орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ, хамгаалж тохижуулсан булаг шанд, усны эх үүсвэрийн тоо, 1 хүнд ногдох байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлын хэмжээ гэсэн 3 үзүүлэлт байна.



	Үзүүлэлт	Томъёолол
4.6.1	Нэг хүнд ногдох орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн 1 хүнд ногдох хэмжээг илэрхийлнэ.</p> <p>Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээг сумын хүн амын тоонд харьцуулж тооцно.</p> $\text{ОНТХГН}_{\text{бх}} = \frac{\text{ОНТХГНХ}}{\text{СХАТ}}$ <p>$\text{ОНТХГН}_{\text{бх}}$ - 1 хүнд ногдох орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ</p> <p>ОНТХГНХ-Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ (га) СХАТ-Сумын хүн амын тоо</p>
4.6.2	Хамгаалж тохижуулсан булаг шанд, усны эх үүсвэр	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын нийт булаг шанд, усны эх үүсвэрээс хамгаалж тохижуулсан булаг шанд, усны эх үүсвэрийн эзлэх хувийг илэрхийлнэ.</p> <p>Хамгаалж тохижуулсан булаг шанд, усны эх үүсвэрийн тоог нийт булаг шанд, усны эх үүсвэрт харьцуулж тооцно.</p> $\text{ХТБШУЭҮ}_{\text{бх}} = \frac{\text{ХТУЭҮНТ}}{\text{НУЭТ}}$ <p>$\text{ХТБШУЭҮ}_{\text{бх}}$ - Хамгаалж тохижуулсан булаг шанд, усны эх үүсвэр</p> <p>ХТУЭҮНТ - Хамгаалж тохижуулсан булаг шанд, усны эх үүсвэрийн тоо НУЭТ - Нийт булаг шанд, усны эх үүсвэрийн тоо</p>



<p>4.6.3</p>	<p>1 хүнд ногдох байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хэмжээ</p>	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: 1хүнд ногдох байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хэмжээг илэрхийлнэ.</p> <p>Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хэмжээг сумын нийт хүн амд харьцуулж тооцно.</p> $\text{БОХНСЗХ}_{\text{бх}} = \frac{\text{БОХНСЗХ}}{\text{СХАТ}}$ <p>БОХНСЗХ_{бх} - 1хүнд ногдох байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хэмжээ БОХНСЗХ-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хэмжээ СХАТ-Сумын хүн амын тоо</p>
<p>4.7. Эдийн засаг-тухайн сумын төсөв, санхүүгийн байдал ямар түвшинд байгаа болон иргэдийн бизнес эрхлэлтийн байдлыг тодорхойлно. Энэ бүлэгт 1 хүнд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээ, 1 хүнд ногдох хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ, 1 хүнд ногдох үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээ, 1 хүнд ногдох татварын орлогын хэмжээ, бизнес эрхлэлтийн түвшин гэсэн 5 үзүүлэлт багтана.</p>		
<p>4.7.1</p>	<p>Үзүүлэлт</p> <p>1 хүнд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээ</p>	<p>Томъёолол</p> <p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын хөрөнгө оруулалтын 1 хүнд ногдох хэмжээг илэрхийлнэ.</p> <p>Сумын нийт хөрөнгө оруулалтын хэмжээг нийт хүн амын тоонд харьцуулж тооцно. (Улсын төсөв, орон нутгийн төсвөөс тухайн суманд хуваарилагдсан төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө хамаарна)</p> $\text{НХНХОХ}_{\text{тс}} = \frac{\text{СНХОХ}}{\text{СХАТ}}$ <p>НХНХОХ_{тс} - Нэг хүнд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээ СНХОХ- Сумын нийт хөрөнгө оруулалтын хэмжээ СХАТ- Сумын хүн амын тоо</p>



<p>4.7.2</p>	<p>1 хүнд ногдох хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ</p>	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын хадгаламжийн үлдэгдлийн 1 хүнд ногдох хэмжээг илэрхийлнэ.</p> <p>Оны эцсийн хадгаламжийн үлдэгдлийн хэмжээг нийт хүн амд харьцуулж тооцно.</p> $НХНХҮХ_{TC} = \frac{ОЭҮҮХ}{СХАТ}$ <p>НХНХҮХ_{TC} - 1 хүнд ногдох хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ</p> <p>ОЭҮҮХ-Оны эцсийн хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ (сая.төг)</p> <p>СХАТ- Сумын хүн амын тоо</p>
<p>4.7.3</p>	<p>1 хүнд ногдох үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээ</p>	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдлийн 1 хүнд ногдох хэмжээг илэрхийлнэ.</p> <p>Оны эцсийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээг нийт хүн амд харьцуулж тооцно.</p> $НХНЗҮХ_{TC} = \frac{ОЭЗҮХ}{СХАТ}$ <p>НХНЗҮХ_{TC} - 1 хүнд ногдох үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээ</p> <p>ОЭЗҮХ-Оны эцсийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээ (сая.төг)</p> <p>СХАТ- Сумын хүн амын тоо</p>



<p>4.7.4</p>	<p>1 хүнд ногдох татварын орлогын хэмжээ</p>	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумаас улс, орон нутаг (аймаг, сумын)-ийн төсөвт төвлөрүүлж байгаа татварын орлогын 1 хүнд ногдох хэмжээг илэрхийлнэ.</p> <p>Тухайн сумаас улс, орон нутаг (аймаг, сумын)-ийн төсөвт төвлөрүүлж байгаа татварын орлогыг нийт хүн амын тоонд харьцуулж тооцно.</p> $НХНТОХ_{тс} = \frac{СТОХ}{СХАТ}$ <p>НХНТОХ_{тс} - 1 хүнд ногдох татварын орлогын хэмжээ</p> <p>СТОХ-Тухайн сумаас улс, орон нутаг (аймаг, сумын)-ийн төсөвт төвлөрүүлж буй татварын орлогын хэмжээ (сая.төг) СХАТ-Сумын хүн амын тоо</p>
<p>4.7.5</p>	<p>Бизнес эрхлэлтийн түвшин</p>	<p>Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн сумын нийт өрхөд жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа өрхийн эзлэх хувийг илэрхийлнэ.</p> <p>Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа өрхийн тоог нийт өрхийн тоонд харьцуулж тооцно.</p> $БЭТ_6 = \frac{ЖДҮЭӨТ}{НӨТ}$ <p>БЭТ₆ - Бизнес эрхлэлтийн түвшин ЖДҮЭӨТ- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч өрхийн тоо НӨТ- Нийт өрхийн тоо</p>

4.8. Сумын хөгжлийн индекс тооцох эерэг, сөрөг үзүүлэлтүүд

Хөгжлийн индекс тооцох үзүүлэлтүүдийг шинж чанараас нь хамааруулж эерэг болон сөрөг гэсэн хоёр бүлэгт ангилна.

Эерэг үзүүлэлт-стандарт түвшинд хүргэх, амьдрах орчны нөхцөлийг сайжруулахын тулд тухайн үзүүлэлтийн үр дүнг өсгөхийг зорилт болгох үзүүлэлтүүд. Жишээ нь: Эрчим хүч, ажиллах хүчний оролцоо зэрэг.



Хөгжлийн индекс тооцох эерэг үзүүлэлтүүд

1	Хүн амын нягтшил	+
2	Ажиллах хүчний оролцоо	+
3	Цэцэрлэгт хамрагдалтын индекс	+
4	Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт	+
5	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	+
6	Дотуур байрны хүрэлцээ хангамж	+
7	Ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициент	+
8	100 хүнд ногдох соёл урлагийн байгууллагын суудлын хүртээмж	+
9	100 хүнд ногдох эмнэлгийн мэргэжилтний тоо	+
10	100 хүнд ногдох эмнэлгийн үйлчилгээний хүртээмж	+
11	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан албан байгууллага, өрхийн хувийн жин	+
12	Дулаан хангамжийн системд холбогдсон барилга байгууламжийн хувийн жин	+
13	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрт хамрагдсан албан байгууллага, өрхийн хувийн жин	+
14	Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон албан байгууллага, өрхийн хувийн жин	+
15	Төвлөрсөн болон бие даасан инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн хувийн жин	+
16	Шилжилт хөдөлгөөн	+
17	Гэмт хэрэг илрүүлэлтийн хувийн жин	+
18	Иргэдийн оролцоо	+
19	Хөрөнгө оруулалтын зарцуулалтын хувийн жин	+
20	Бэлчээр, хадлангийн 100 га талбайд ногдох малын тоо	+
21	Тариалангийн зориулалттай нийт талбайн ашиглалтын хувь	+
22	Нийт хүн амд малчдын эзлэх хувийн жин	+
23	1 хүнд ногдох малын тоо	+
24	Нийт малчин өрхийн малчин хоршоонд хамрагдалтын хувийн жин	+
25	1 хүнд ногдох орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ	+
26	Хамгаалж тохижуулсан булаг шанд усны эх үүсвэр	+
27	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хэмжээ	+
28	1 хүнд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээ	+



29	1 хүнд ногдох хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ	+
30	1 хүнд ногдох үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээ	+
31	1 хүнд ногдох татварын орлогын хэмжээ	+
32	Бизнес эрхлэлтийн түвшин	+

Сөрөг үзүүлэлт-стандарт түвшинд хүргэх, амьдрах орчны нөхцөлийг сайжруулахын тулд тухайн үзүүлэлтийн үр дүнг бууруулахыг зорилт болгох үзүүлэлтүүд. Жишээ нь: Ажилгүйдлийн түвшин юм.

Хөгжлийн индекс тооцох сөрөг үзүүлэлтүүд

1	Ажилгүйдлийн түвшин	-
---	---------------------	---

Сумын хөгжлийн нэгдсэн индекс, индексийн өөрчлөлтийг тооцох арга

1. Эерэг үзүүлэлтийг доорх томъёогоор тооцно.

$$i^{th} \text{ сум} = \frac{V_i - V_{min}}{V_{max} - V_{min}}$$

2. Сөрөг үзүүлэлтийг доорх томъёогоор тооцно.

$$i^{th} \text{ сум} = \frac{V_{max} - V_i}{V_{max} - V_{min}}$$

$i^{th} \text{ сум} - i$ сумын үзүүлэлтийн хувийн индекс

$V_i - i$ сумын V үзүүлэлтийн утга;

V_{min} - Ангилал доторх сумын V үзүүлэлтийн хамгийн бага утга

V_{max} - Ангилал доторх сумын V үзүүлэлтийн хамгийн их утга

Дээрх томъёогоор тус тус тооцож үзүүлэлтийн хувийн индексийг гаргасны дараа жигнэсэн (бүлэг бүрийг адил жинтэйгээр тооцно=1/7) нийлбэр дүнгээр сумын хөгжлийн индексийг тооцно.



3. Бүлэг бүрт адил 0,143 гэсэн хувийн жинг тооцоонд ашиглана.

4. Үзүүлэлт бүрийн хувийн жин J нь $0,143/T$ байна. Энд, T -тухайн үзүүлэлтийг агуулж буй бүлэг дэх үзүүлэлт.

5. Аль ч орон нутгийн хувьд үзүүлэлтүүдийн хувийн жингийн нийлбэр $\sum_1^{33} J = 1$ байна.

6. Бүх сумын хувьд нийлмэл индекс (СХИ)-ийг $СХИ = \sum_1^{33} J * TI$ томъёогоор тооцно.

7. Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Сумдын хөгжлийн загвар”-ын дагуу аймгийн төвийн сумдаас бусад сумдын хөгжлийн индексийг хүн амын тооноос нь хамааруулан 3000 хүртэл, 3001-5000, 5001-с дээш, онцлог сум гэж 4 ангилж, ангилал тус бүрээр тооцон хамгийн их утгаас буурах дарааллаар эрэмбэлнэ.

8. Тухайн жилд Сумын хөгжлийн индексийг хамгийн ихээр ахиулсан сумдыг шалгаруулахдаа СХИ-ийн өөрчлөлт ($\Delta СХИ$)-өөр буюу ахисан утгын дарааллаар ангилал тус бүрээр эрэмбэлнэ.

Индексийн өөрчлөлтийг тооцохдоо 2013 оныг суурь он болгох бөгөөд 4 жил тутамд суурь оныг шинэчилнэ.

$$\Delta СХИ = СХИ_1 - СХИ_0$$

$\Delta СХИ$ - Сумын хөгжлийн индексийн өөрчлөлт

$СХИ_1$ - Өмнө (2 жилийн өмнө) тооцсон сумын хөгжлийн индекс

$СХИ_0$ - Тухайн жилд тооцсон сумын хөгжлийн индекс

Тав. Сумын хөгжлийн индексийн тооцооны
үр дүнг ашиглах, нийтэд мэдээлэх

5.1. Сумын хөгжлийн индексийг Эдийн засгийн хөгжлийн яам 2 жилд нэг удаа тооцож нийтэд мэдээлнэ.

5.2. Индексийг таслалаас хойш 5 орны тооны түвшинд гаргана.

5.3. Сумын хөгжлийн индекс тооцох аргачлалд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Эдийн засгийн хөгжлийн яам хариуцна.

Засгийн газрын 2014 оны 242 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

СУМЫН ХӨГЖЛИЙН ИНДЕКС ТООЦОХОД ШААРДАГДАХ МЭДЭЭЛЭЛ,
ТЭДГЭЭРИЙГ ГАРГАХ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

д/д	Бүлэг	Үзүүлэлт	Шаардагдах мэдээлэл	Шаардагдах мэдээллийг гаргах байгууллага	
1	Хүн ам	1.1	Хүн амын нягтшил	Сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээ	ҮСХ
		1.2	Ажиллах хүчний оролцоо	Ажил хийдэг хүний тоо Хөдөлмөрийн насны хүн амын тоо (15-59нас)	ҮСХ ҮСХ
2	Нийгмийн үйлчилгээ	2.1	Цэцэрлэг хамрагдалтын индекс	Цэцэрлэг хамрагдаж байгаа хүүхдийн тоо	ҮСХ, БШУЯ, бүх шатны Засаг дарга
				Сургуулийн өмнөх боловсролд хамрагдвал зохих (2-5 нас) хүүхдийн тоо	ҮСХ, БШУЯ, бүх шатны Засаг дарга
		2.2	Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт	Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа мэргэжилтэй багшийн тоо	ҮСХ, БШУЯ, бүх шатны Засаг дарга
				Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа нийт багшийн тоо	ҮСХ, БШУЯ, бүх шатны Засаг дарга
		2.3	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	Сургуульд сурч байгаа 6-14 насны хүүхдийн тоо	ҮСХ, БШУЯ, бүх шатны Засаг дарга
			Суурь боловсрол эзэмшвэл зохих нийт хүүхдийн тоо	ҮСХ, БШУЯ, бүх шатны Засаг дарга	





3	Засаглал	2.4	Дотуур байрны хүрэлцээ хангамж	Дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн тоо	БШУЯ, бүх шатны Засаг дарга
			Дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан хүүхдийн тоо	БШУЯ, бүх шатны Засаг дарга	
		2.5	Ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициент	Тухайн сургуульд суралцаж байгаа хүүхдийн тоо	БШУЯ, бүх шатны Засаг дарга
				Хичээлийн байрны төлөвлөгдсөн хүчин чадал	БШУЯ, бүх шатны Засаг дарга
		2.6	100 хүнд ногдох соёл урлагийн байгууллагын суудлын хүртээмж	Соёл урлагийн байгууллагын суудлын тоо	ССАЖЯ, бүх шатны Засаг дарга
				Сумын хүн амын тоо	
		2.7	100 хүнд ногдох эмнэлгийн мэргэжилтний хүртээмж	Тухайн сумын эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний тоо	ҮСХ, ЭМЯ, бүх шатны Засаг дарга
				Сумын хүн амын тоо	ҮСХ
		2.8	100 хүнд ногдох эмнэлгийн үйлчилгээний хүртээмж	Эмнэлгийн орны тоо (хүчин чадал)	ЭМЯ, бүх шатны Засаг дарга
				Сумын хүн амын тоо	ҮСХ
3.1	Ажилгүйдлийн түвшин	Ажилгүй иргэдийн тоо	ҮСХ, ХЯ, бүх шатны Засаг дарга		
		Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо		ҮСХ	
3.2	Шилжилт хөдөлгөөн	Шилжин ирэгсдийн тоо	ҮСХ		
		Шилжин явагсдын тоо	ҮСХ		
3	Засаглал	3.2	Оны эхэнд байсан хүн амын тоо	ҮСХ	
			Оны сүүлд байсан хүн амын тоо	ҮСХ	

5	Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ	4.4	1 хүнд ногдох малын тоо	Сумын малын тоо	ҮСХ	
			Сумын хүн амын тоо	Сумын хүн амын тоо	ҮСХ	
		4.5	Нийт малчин өрхийн малчин хоршоонд хамрагдалтын хувийн жин	Хоршоонд хамрагдсан малчин өрхийн тоо	Хоршоонд хамрагдсан малчин өрхийн тоо	ҮСХ, ҮХААЯ, бүх шатны Засаг дарга
				Тухайн сумын малчин өрхийн тоо	Тухайн сумын малчин өрхийн тоо	ҮСХ, бүх шатны Засаг дарга
		5.1	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан албан байгууллага, өрхийн хувийн жин	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан байгууллагын тоо	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан байгууллагын тоо	ҮСХ, бүх шатны Засаг дарга
				Нийт албан байгууллагын тоо	Нийт албан байгууллагын тоо	ҮСХ, бүх шатны Засаг дарга
				Цахилгаан эрчим хүчээр хангагдсан нийт өрхийн тоо	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан нийт өрхийн тоо	ҮСХ, бүх шатны Засаг дарга
				Нийт өрхийн тоо	Нийт өрхийн тоо	ҮСХ
		5.2	Дулаан хангамжийн системд холбогдсон барилга байгууламжийн хувийн жин	Дулаан хангамжийн системд холбогдсон барилга байгууламжийн талбай (кв/м) (төсвийн байгууллага, зочид буудал, зоогийн газар, ахуй үйлчилгээний барилга)	Дулаан хангамжийн системд холбогдсон барилга байгууламжийн талбай (кв/м) (төсвийн байгууллага, зочид буудал, зоогийн газар, ахуй үйлчилгээний барилга)	ҮСХ, БХБЯ, бүх шатны Засаг дарга
				Барилга байгууламжийн талбай (кв/м) (төсвийн байгууллага, зочид буудал, зоогийн газар, ахуй үйлчилгээний барилга)	Барилга байгууламжийн талбай (кв/м) (төсвийн байгууллага, зочид буудал, зоогийн газар, ахуй үйлчилгээний барилга)	ҮСХ, БХБЯ, бүх шатны Засаг дарга



<p>Төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнээс ус түгээх шугамаар дамжуулан усаар найдвартай тасралтгүй хангагддаг болон стандартын шаардлага хангасан төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон албан байгууллагын тоо</p>	<p>ҮСХ, БОНХЯ, БХБЯ, бүх шатны Засаг дарга</p>
<p>Нийт албан байгууллагын тоо</p>	<p>ҮСХ, бүх шатны Засаг дарга</p>
<p>Төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнээс ус түгээх шугамаар дамжуулан усаар найдвартай тасралтгүй хангагддаг болон стандартын шаардлага хангасан төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон өрхийн тоо</p>	<p>ҮСХ, БОНХЯ, БХБЯ, бүх шатны Засаг дарга</p>
<p>Нийт өрхийн тоо</p>	<p>ҮСХ</p>
<p>Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон албан байгууллагын тоо (төсвийн байгууллага, зочид буудал, зоогийн газар, ахуй үйлчилгээний барилга)</p>	<p>ҮСХ, БОНХЯ, БХБЯ, бүх шатны Засаг дарга</p>
<p>Нийт албан байгууллагын тоо (төсвийн байгууллага, зочид буудал, зоогийн газар, ахуй үйлчилгээний барилга)</p>	<p>ҮСХ, бүх шатны Засаг дарга</p>
<p>Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон нийт өрхийн тоо</p>	<p>ҮСХ, БОНХЯ, БХБЯ, бүх шатны Засаг дарга</p>
<p>Шаардлага хангасан ундны эх үүсвэрт хамрагдсан албан байгууллага, өрхийн хувийн жин</p>	<p>5.3</p>
<p>Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон албан байгууллага, өрхийн хувийн жин</p>	<p>5.4</p>

			Нийт өрхийн тоо	ҮСХ
		Төвлөрсөн болон бие даасан инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн тоо	Төвлөрсөн болон бие даасан инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн тоо	ҮСХ, БХБЯ, бүх шатны Засаг дарга
	5.5	Төвлөрсөн болон бие даасан инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн хувийн жин	Нийт өрхийн тоо	ҮСХ, бүх шатны Засаг дарга
	6.1	1 хүнд ногдох орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ (га)	ҮСХ, БОНХЯ, бүх шатны Засаг дарга
	6.2	Хамгаалж тохижуулсан булаг шанд, усны эх үүсвэр	Сумын хүн амын тоо	ҮСХ
6	Байгаль хамгаалал	Хамгаалж тохижуулсан булаг шанд, усны эх үүсвэр	Хамгаалж тохижуулсан булаг шанд, усны эх үүсвэрийн тоо	ҮСХ, БОНХЯ, бүх шатны Засаг дарга
	6.3	1 хүнд ногдох байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хэмжээ	Тухайн сумын нутаг дэвсгэрт хамаарах нийт булаг шанд, усны эх үүсвэрийн тоо	ҮСХ, БОНХЯ, бүх шатны Засаг дарга
	7	Эдийн засаг	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хэмжээ (сая.төг)	ҮСХ, БОНХЯ, бүх шатны Засаг дарга
	7.1	1 хүнд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээ	Сумын хүн амын тоо	ҮСХ
			Тухайн сумын нийт хөрөнгө оруулалтын дүн (сая.төг) (Улсын төсөв, орон нутгийн төсвөөс тухайн суманд хуваарилгдсан төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө хамаарна)	ҮСХ, СЯ, бүх шатны Засаг дарга
			Сумын хүн амын тоо	ҮСХ



			Тухайн сумын оны эцсийн хадгаламжийн үлдэгдэл (сая.төг)	Монгол банк, бүх шатны Засаг дарга
	7.2	1 хүнд ногдох хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ	Сумын хүн амын тоо	ҮСХ
	7.3	1 хүнд ногдох үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээ	Оны эцсийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээ (сая.төг)	Монгол банк, бүх шатны Засаг дарга
	7.4	1 хүнд ногдох татварын орлогын хэмжээ	Сумын хүн амын тоо	ҮСХ
	7.5	Бизнес эрхлэлтийн түвшин	Тухайн сумаас улс, орон нутаг (аймаг, сумын)-ийн төсөвт төвлөрүүлж буй татварын орлогын дүн (сая.төг)	ҮСХ, СЯ, ТЕГ, бүх шатны Засаг дарга
			Сумын хүн амын тоо	ҮСХ
			Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч өрхийн тоо	ҮСХ, УХААЯ, бүх шатны Засаг дарга
			Нийт өрхийн тоо	ҮСХ



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2014 оны 09 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 11.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Ш.Цогтоо/илтгэгч/, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч Нийслэлийн Баянгол дүүргийн 9 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Мэргэн оролцож, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 13/, 17/ дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 9 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Мэргэн Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээлэлдээ:

Улсын Их Хурлаас 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын “нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчин” гэдэгт хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчин хамаарахгүй” /цаашид “ХДХВ/ДОХ” гэх/ гэсэн хэсэг нэмсэн. Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүлийн нууц гэдгийг энэ хуульд дараах утгаар ойлгоно.” гээд 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад “эрүүл мэндийн нууцад тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг;” гэж заасан. Хуулийн дурдсан хэсэг, заалтаас харахад хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчнөөр өвчилсөн хүний мэдээллийг хувь хүний нууцын төрлөөс хассан байна. Ингэснээр Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн



1 дэх хэсгийн "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... ялгаварлан гадуурхаж үл болно.", Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын "... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, ... -ыг хуулиар хамгаална;", мөн зүйлийн 17 дахь заалтын "... Хүний эрх, нэр төр, алдар хүнд, ...-г хангах зорилгоор задруулж үл болох ... хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэснийг тус тус зөрчсөн байна.

1. Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн тухайд: Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш, адил байна гэдэг нь хууль тогтоогчийн болон хэрэглэгчийн зүгээс хүн бүрт эрх, үүрэг, хариуцлага гурвыг ямар нэг ялгаваргүй тогтоох хэрэгжүүлэх зарчим юм. Өөрөөр хэлбэл хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлаж, аль нэг хэсэгт нь давуу буюу дутуу эрх олгох, илүү үүрэг хүлээлгэх буюу үүргээс чөлөөлөх хууль гаргаж болохгүй гэсэн үг. Гэтэл Хувь хүний нууцын тухай хуулиар "Хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол" өвчинтэй хүний мэдээллийг онцгойлон нууцаас хассан нь Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчиж байна. ...

2. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13/, 17/ дахь заалтын тухайд: Иргэний хувийн нууц гэдэгт тухайн этгээд өөрийн нэр төр, алдар хүндэд харшилна гэж үзэж бусдад мэдэгдэхээс нууцалж явдаг бие, эрхтний гажиг согогоос эхлээд нэр төртэй нь холбоотой бүхий л зүйл хамаарах бөгөөд эрх зүйн онолд нэр төр гэдгийг тухайн хүн өөрөө өөрийгөө болон бусад этгээдээр хэрхэн үнэлүүлэхээ шийдвэрлэх эрх гэж үздэг. Үндсэн хуульд энэ эрхийг нь баталгаажуулж иргэний хувийн нууцыг хуулиар хамгаалах заалт тусгасан.

Энд нийтийн ашиг сонирхол, бусдын эрхийг хамгаалах зорилгоор хүний эрхийг зүй ёсоор хязгаарлах тухай яригдаж болох юм. Хэдийгээр Үндсэн хуульд ёсны үзэл баримтлалаар ардчиллын зарчмаар гарч ирсэн хууль тогтоогч хууль батлах замаар иргэний үндсэн эрхийг хөндөж болох ч үүнд зайлшгүй баримтлах ёстой зарчим бол хязгаарлалт нь үндсэн эрхийг хэдий чинээ хөндөхөөр байна төдий чинээ хуулиар тогтоосон эрх зүйн үндэслэлүүд нь "тодорхой байх ёстой" гэсэн эрх зүйт ёсны формал шаардлага хангагдаж байх учиртай. Хувь хүний нууцын тухай болон бусад хуульд нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчин гэдэгт ямар өвчнүүдийг хамааруулах, хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол энэ ангилалд ямар учраас багтаж байгаа тухай нэр томъёоны хийгээд бусад тайлбар, тодорхойлолт байхгүй атлаа нийтэд аюултай гэсэн тодорхойгүй шалтгаанаар хувь хүний нууцаас хассан байна.

3. Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн тухайд:

Төрөөс хүний эрхийг хангахад зориулан бүрдүүлэх баталгаа нь эдийн засгийн, нийгмийн, хууль зүйн болон бусад хэлбэрийн арга хэмжээнүүдэд илрэх ёстой. ...

Орчин үеийн Үндсэн хуульд ёсны онолоор үндсэн эрхийг хязгаарлах зайлшгүй шаардлага гэдэгт нийтээр хүлээн зөвшөөрсөн төрийн эрхэм зорилго, тухайлбал, нийгмийн дэг журмыг сахин хамгаалах, нийт иргэдийн сайн сайхан байдлыг хангах, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зэргийг ойлгох хандлага түгээмэл байна. Энд мөн л хүний эрхийг хязгаарлах болсон үндэслэл нь тодорхой байх гэсэн зарчим яригдах бөгөөд хууль тогтоогчийн зүгээс хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол өвчин нь “нийтэд онцгой аюултай халдварт өвчин” учраас тухайн иргэний эрхийг хязгаарлах нь зүйтэй гэсэн бололтой.

Хувь хүний нууцын тухай хуульд “Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх” тухай хуулийг шинэчлэн найруулсантай холбоотойгоор дагаж өөрчлөгдөх хуулийн хүрээнд нэмэлт оруулсан бөгөөд ингэхдээ үндэслэл болсон хуулийнхаа эсрэг үзэл баримтлал бүхий хэсэг нэмсэн нь хүний эрхийг хязгаарлах болсон зайлшгүй шаардлагыг тодорхой бус харин ч бүрхэгдүүлж байна. Энэ нь Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 11 зүйлийн 11.3 болон холбогдох бусад заалтуудад байгууллага, албан тушаалтан, иргэнд хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолтой хүний талаарх мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахгүй байхыг үүрэг болгосон байгаагаас харагдана.

Мөн хууль тогтоогчийн зүгээс www.parliament.mn цахим хуудсанд баталсан хуулийнхаа танилцуулгыг нийтлэхдээ “... Нэгдсэн Үндэсний Байгууллагын хүний эрхийн байгууллагаас хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ, судалгаанаас үзэхэд Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлал олдмол хомсдолтой хүмүүсийн ... хувь хүний нууцын халдашгүй байдал зэрэг хүний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдөх магадлал өндөр түгээмэл байгаа талаар анхааруулсан. ... Хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдолтой хүмүүсийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг хориглож ... эдгээр хүмүүсийн талаарх мэдээллийг задруулахгүй байхыг хуульчиллаа. ... Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, хүний эрхийн талаарх олон улсын гэрээ, конвенцийн заалттай үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх, хүний эрхийг хамгаалах асуудлыг цогцоор нь оновчтой болгон хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагын улмаас хууль баталлаа...” гэсэн байгаа нь Хувь хүний нууцаар хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдолтой хүмүүсийн мэдээллийг нууцаас хасах зайлшгүй шаардлагыг тодорхойлсон бус харин ч эсрэг үзэл баримтлалуудыг дурдсан байна.



Иймд Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг нь Үндсэн хуулийн холбогдох хэсэг, заалтуудыг зөрчсөн байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү” гэжээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын даргын 2014 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 72 дугаар захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн 3.Баянсэлэнгэ Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“...Монгол Улс Хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалт харьцангуй бага орнуудын тоонд багтаж байгаа хэдий ч хүний дархлал хомсдолын вирусын халдвар тархах нөхцөл байдал, эрсдэл түгээмэл бөгөөд сүүлийн жилүүдэд халдварын тохиолдлын тоо өсөн нэмэгдэж байна. Түүнчлэн Монгол Улс Нэгдсэн Үндэсний Байгууллагаас гаргасан хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан болон дархлалын олдмол хомсдолтой хүний эрхийг хамгаалах, нийтийн дэмжлэгт орчинг бүрдүүлэх уриалга болон хүний эрхийн олон улсын байгууллагуудаас өгч буй зөвлөмжүүдийг харгалзан үзэж эрх зүйн орчноо боловсронгуй болгосон.

Тухайлбал, Улсын Их Хурлаас Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдөр баталжээ. Түүнчлэн дээр дурдсан хуультай нийцүүлэн хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан болон дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргаж байхаар заасан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг хүчингүй болгож, улмаар халдвар авсан болон дархлалын олдмол хомсдолтой хүний эрхийг хамгаалахтай холбогдсон эрх зүйн зарим зохицуулалтыг холбогдох хуульд нэмэлт болгон оруулсан.

Үүний дотор “Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчин” гэдэгт хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчин хамаарахгүй” гэсэн зохицуулалт болно.

1.Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтын тухайд: Үндсэн хуулийн “хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш байна” гэдэг нь хууль тогтоох болон гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтанд хамааралтай заалт бөгөөд хүнийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах явдлыг хориглосон зохицуулалт нь хүн хууль, шүүхийн өмнө эрх тэгш байхын илэрхийлэл буюу нийтлэг шинж чанарыг агуулж байна. Иймд мэдээлэл гаргагчийн бичиж байгаачлан хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан болон дархлалын олдмол хомсдол өвчтэй хүний талаарх мэдээллийг онцгойлон нууцаас хасч эрхийг нь зөрчсөн гэж үзэхгүй байгаа болно.

2. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13/ болон 17/ дахь заалтын тухайд: Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 12 дугаар, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйлд тус тус заасанчлан “хэний ч хувийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох ёсгүй. Ийнхүү оролцох гэвэл хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй” гэсэн байдаг. Үүнээс үзэхэд хувь хүний нууц бол хүний халдашгүй эрх мөн бөгөөд энэ эрх нь зөрчигдсэн тохиолдолд Иргэний хуулийн 21.4-т заасан ёсоор хуульчилж тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүй тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.

Түүнчлэн хувь хүний нууцыг задруулсан бол холбогдох хуулийн дагуу захиргааны улмаар Эрүүгийн хуулийн 136 дугаар зүйлд заасанчлан эрүүгийн хариуцлагыг тус тус хүлээлгэдэг. Энэхүү эрх зүйн механизм нь Үндсэн хуулийн дээр дурдсан зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болох билээ.

Мэдээлэл гаргагч мэдээлэлдээ “нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчин” гэдэгт ямар өвчин хамаарч байгаа, тэдгээрт хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол багтаж буй эсэх нь тодорхойгүй” гэжээ. Нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчний жагсаалтыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тогтоодог бөгөөд тэдгээрт хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол хамаарахгүй. Харин Монгол Улсын хууль тогтоомжид энэ зохицуулалт тодорхой тусгагдаагүй билээ.

1995 онд баталсан Хувь хүний нууцын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасанчлан Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хувь хүний нууц хэмээн ойлгоно.

Түүнчлэн “хувь хүний эрүүл мэндийн нууц” нь зөвхөн дээр дурдсан хуулийн зохицуулах зүйл биш билээ. Учир нь хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан болон дархлалын олдмол хомсдолтой хүний эрхийг хамгаалсан бөгөөд түүний талаарх мэдээллийг задруулахыг хориглосон заалтыг илүү нарийвчилсан зохицуулалттай хууль буюу Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай шинэчлэн найруулсан хуульд тусгажээ.

3. Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн тухайд:

Хүний эрх, эрх чөлөө нь бүх хүнд адил заяасан төрөлх шинжтэй бөгөөд хүний эрхийг хамгаалах нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын анхдагч үүрэг болдог байна. Монгол Улс хүний эрхийг хамгаалах төрийн бүтэц болох хүний эрхийн хэрэгжилтийг хянах бие даасан механизм буюу Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссыг



байгуулсан. Мөн хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх бие даасан хараат бус захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо бүрэлдэн төлөвшиж хүний эрхийн хэрэгжилтэд чухал нөлөө үзүүлж байна.

Иймд Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

Харин Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцэд итгэмжилсэн төлөөлөгч томилж, хариу тайлбар гаргах тухай асуудлыг хэлэлцсэн билээ. Тус хуралдаан дээр Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлд оруулсан дээрх нэмэлт нь Үндсэн хуулийн зүйл, заалтын шууд зөрчлийг агуулсан гэж үзэхэд хүндрэлтэй боловч хууль хоорондын зөрчил оршиж байгаа талаар Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт, Р.Гончигдорж нар тус тус санал гаргаж байв.

Иймд Улсын Их Хурлын гишүүн миний бие Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хуулийн төсөл санаачилан боловсруулж, өргөн мэдүүлэн дээр дурдсан зөрчлийг арилгана.” гэжээ.

Гурав. Монгол Улсын Эрүүл мэндийн сайд Н.Удвал 2014 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 1а/3026 дугаарт албан бичгээр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол нь **“нийтэд аюултай онцлог халдварт өвчин”** биш юм. Иймд “Хувь хүний нууцын тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн тухайн заалт нь найруулгын алдаа гарснаас хувь хүний нууц алдагдахад хүрэх тул найруулан өөрчлөх саналтай байна.

Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005)-д заасны дагуу “Гишүүн улс бүр өөрийн нутаг дэвсгэрт гарсан ноцтой байдалд үнэлгээ дүгнэлт өгч, ер бусын, гэнэтийн, хүний эрүүл мэндэд ноцтой нөлөөлж болох доорх өвчнүүдийг мэдээлэх ёстой. Үүнд:

- Цагаан цэцэг;
- Зэрлэг полио вирусээр үүсгэгдсэн полимелит;
- Шинэ дэд төрлөөр үүссэн хүний томуу;
- Амьсгалын цочмог халтай хамшинж (SARS);
- Булчин задрах тахал;
- Уушгины тахал (тарваган тахлын уушгины хэлбэр);
- Шар чичрэг;
- Вируст цусархаг чичрэгүүд (эбола, ласса, марбургийн чичрэг, өрнөд Нилийн чичрэг)



- Үндэсний ба бүсийн онцгой асуудал болох бусад өвчнүүд /денге чичрэг, Рифтийн хөндийн чичрэг, менингоккт халдвар ... гэх мэт/.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13/ дахь заалтад иргэний хувийн ба гэр бүл, нууцыг хуулиар хамгаална гэж, мөн зүйлийн 17/ дахь заалтад хүний эрх, нэр төр, алдар хүндийг хангах зорилгоор задрүүлж үл болох хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаалахаар заасан. Гэтэл Монгол Улсын Их Хурал 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын “нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчин” гэдэгт хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчин хамаарахгүй” гэж нэмэлт оруулсан нь хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой болох нь тогтоогдсон хүний хувийн нууцад халдах боломжийг бүрдүүлж, улмаар тухай хүний нэр төр, алдар хүндэд нөлөөлөх ноцтой үр дагавар үүсгэхээр байна.

Иймд Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн дээрх заалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13/,17/ дахь заалтын агуулгад үл нийцсэн, хувь хүний нууцыг хуулиар хамгаалах Үндсэн хуулийн зарчимд харшилсан, улмаар Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэсэн заалтыг зөрчсөн шинжийг агуулсан байна.

2. Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын “нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчин” гэдэгт хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчин хамаарахгүй” гэж хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын “нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчин” гэдэгт хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчин хамаарахгүй” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13/



дахь заалтын “... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, ... -ыг хуулиар хамгаална;”, мөн зүйлийн 17/ дахь заалтын “ ... Хүний эрх, нэр төр, алдар хүнд, ...-г хангах зорилгоор задруулж үл болох ... хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын “нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчин” гэдэгт хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчин хамаарахгүй” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчөөгүй байна.

3. Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын “нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчин” гэдэгт хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчин хамаарахгүй” гэсэн заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2014 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Н.ЖАНЦАН

ГИШҮҮД

**П.ОЧИРБАТ
Ш.ЦОГТОО
Д.СОЛОНГО
Д.ГАНЗОРИГ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 3

Индекс: 14003